



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/170

Номгон

Орон тооны бус зөвлөл болон устгах, худалдан
борлуулах, үнэлэх комисс байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, улсын орлого болгох, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, зөвлөлийн дэргэд ажиллах устгалын комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар, худалдан борлуулах комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар, үнэлэх комиссын бүрэлдэхүүнийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн эд зүйлийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, тайлан мэдээг нэгтгэн Прокурорын газарт хагас бүтэн жилээр, Орон нутгийн өмчийн газарт улирал тутам мэдээлж ажиллахыг Орон тооны бус зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

4. Энэ захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн A/402 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Д.МӨНХСАЙХАН

640310435

Аймгийн Засаг даргын 31-ний дугаар сарын
31-ний өдрийн 11:00 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

ХУРААН АВСАН ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЭД ЗҮЙЛ,
ХЭРЭГСЛИЙГ ҮНЭЛЭХ, ХУДАЛДАН БОРЛУУЛАХ,
УЛСЫН ОРЛОГО БОЛГОХ, УСТГАХ ШИЙДВЭР ГАРГАХ,
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга

Аймгийн Онцгой байдлын газрын дарга

Аймгийн Татварын хэлтсийн дарга

Аймгийн Зооноз өвчин судлалын төвийн дарга

Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн
мэргэжилтэн

Аймгийн Статистикийн хэлтсийн үнийн мэдээ, судалгаа хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

ооо

Аймгийн Засаг даргын хөвөнүүсний дугаар сарын
 31-ний өдрийн 2 дугаар захирамжийн
 2 дугаар хавсралт

**ХУРААН АВСАН ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЭДЭҮИЛ,
 ХЭРЭГСЛИЙГ УСТГАХ ШИЙДВЭР ГАРГАХ
 КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга:

Онцгой байдлын газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах
 мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн
 байдал хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Цагдаагийн газрын аж ахуйн ажилтан

ооо

Аймгийн Засаг даргын газрын хөдөлжилтийн
31.....-ний өдрийн дугаар захирамжийн
3 дугаар хувьтэй



**ХУРААН АВСАН ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЭД ЗҮИЛ,
ХЭРЭГСЛИЙГ ХУДАЛДАН БОРЛУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга:

Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн үндэсний хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

Татварын хэлтсийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга


Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн шинжээч

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

ооо

Аймгийн Засаг дарын 2010-жилийн 31-дугаар сарын
 31.-ний өдрүүн 11:17:00 дугаар захиралмжийн
 4 дүгээр хавсралт



**ХУРААН АВСАН ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЭД ЗҮЙЛ,
 ХЭРЭГСЛИЙГ ҮНЭЛЭХ КОМИССЫН
 БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга:

Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хүнс, худалдаа үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч

ооо